



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 26 өдөр

Дугаар 17/282

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлиг, Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны ээлжит XVI хуралдааны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын хүүхдийн спортын их наадамд Хөвсгөл аймгаас оролцох тамирчдын зардалд 10.000.000 (Арван сая) төгрөг, "Үндэсний Номын баярын өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагааны зардалд 1.000.000 (нэг сая) төгрөг, Монгол улсын гавьяат жүжигчин Р.Лхамжавын "Дэлтэй цэнхрийн Лхамжав" тайлан тогтолтод 500.000 (таван зуун мянга) төгрөгийн дэмжлэгийг тус тус олгосугай.

2. Монголын хүүхдийн спортын их наадамд Хөвсгөл аймгаас оролцох тамирчдын зардлын 10.000.000 (Арван сая) төгрөгийг Засаг дарга дансны "Засаг даргын үйл ажиллагааны болон мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх зардал"-аас, "Үндэсний Номын баярын өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагааны болон "Дэлтэй цэнхрийн Лхамжав" тайлан тогтолтын зардлын 1.500.000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс тус тус гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ), нягтлан бодогч (Д.Балжинням) нарт зөвшөөрсүгэй.

3. Олгосон хөрөнгийг холбогдох хууль, журамд нийцүүлэн зориулалтын дагуу зарцуулахыг Биеийн тамир спортын газрын дарга (Б.Очирбат), Нийтийн номын сангийн захирал (Э.Даваачулуун) нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Батбилгүүн)-т даалгасугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ, ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ  М.ХУЯГБААТАР



Захирамж-2023

6712910358